

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-11

<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгар зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i>	3-4
<i>2.Инновац, цахим бодлогын байнгын хорооноос 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Засгийн газар чиглэл өгөх тухай” 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг сонсох</i>	4-11

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
06 дугаар сарын 20-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 14 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Амгалан;
Чөлөөтэй: Х.Ганхуяг, Ц.Сэргэлэн.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгар зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт П.Болорцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Э.Батшугар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Э.Батшугар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Инновац, цахим бодлогын байнгын хорооноос 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Э.Насанбат, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга П.Дэлгэрмаа, “И-Монгол академи” Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран, “Үндэсний дата төв” Улсын төсөвт

үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Т.Батбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт П.Болорцэцэг нар байлцав.

Инновац, цахим бодлогын байнгын хорооноос 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, “И-Монгол академи” Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Инновац, цахим бодлогын байнгын хорооноос 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 14 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 27 минут үргэлжилж, 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Э.БАТШУГАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
14 цаг 14 минут.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Э.Батиугар: Байнгын хорооны эрхэм гишүүд энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүд олонх нь хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулган хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Батиугар 28 дугаар тойрог, Ганибал 12 дугаар тойрог, Идэрбат 18 дугаар тойрог, Ундрам 13 дугаар тойрог, Учрал 28 дугаар тойрог, Чинбүрэн 23 дугаар тойрог. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан Засгийн газарт чиглэл өгөх тухай 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг сонсох. 2 дугаар асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах. Энэ хоёрын дарааллыг өөрчлөөд, эхлээд нь нөгөө нэг тогтоолын

төслөө баталчихъя. Тэгээд дараад нь юу Тогтоолтын хэрэгжилтийг сонсчихъё тэгэх үү? Тэгье. Хаана байгаа билээ?

Нэг. Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгар зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье. Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Инновац, цахим бодлогын байнгын хорооноос тогтоох нь. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийг төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, гишүүдээр Э.Батиугар, Н.Ганибал, Ц.Идэрбат, Б.Саранчимэг.

Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжилтэн, албан хаагчийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэг Ж.Чинбүрэнд зөвшөөрсүгэй. Ийм тогтоол байна.

Цөмөөрөө тогтоолын төслийг баталъя гэсэн, саналтай гишүүд байна уу? Тэгвэл тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Яасан бэ? Тогтоолын төсөл 71,4 хувиар батлагдлаа.

14.18 цаг

Хоёр.Инновац, цахим бодлогын байнгын хорооноос 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг сонсох

2 дугаар асуудалдаа оръё. Инновац, цахим бодлогын байнгын хорооноос 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан Засгийн газарт чиглэл өгөх тухай 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг сонсох. Байнгын хорооны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг сонсох. Хэрэгжилтийн талаарх мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим, хөгжил харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал танилцуулна.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2022 оны чиглэл өгөх тухай 01 дүгээр тогтоолоор цахим шилжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай нийт 11 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд, 1-д иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн систем

сүлжээний чиглэсэн кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах. Кибер халдлага зөрчилд өртсөн мэдээллийн системийг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийг байгуулахад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 493 дугаар тогтоолоор Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг, 2023 оны 42 дугаар тогтоолоор Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрмийг тус тус батлуулсан. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ыг байгуулах, түүний дүрмийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв, программ хангамж, тоног төхөөрөмж бүхий дэд бүтцийг бий болгоход 7,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд уг зардлыг Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацитай байгуулсан Ухаалаг засаг 2 төслийн жагсаалтад оруулж, 2023-2024 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Нийтийн төвийн урсгал зардал 6,2 тэрбум төгрөгийг Цахим, хөгжил харилцаа холбооны сайдын 2024 оны төсөвт тусгахаар ажиллаж байна.

2.Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хүний нөөцийн хөгжил тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хомсдолоос сэргийлэх зорилгоор дунд хугацааны стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн албаны тухай хуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэжсэн, өндөр ур чадвартай хүнийг тухайн чиглэлээр төрийн албанд ажиллуулах шаардлагатай бол албан тушаалын цалингийн итгэлцүүр

шатлалыг Засгийн газрын тогтооно гэж заасны дагуу тус яам Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамтай хамтран цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр түүнийг хэрэглэх төрийн байгууллагуудын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөл холбогдох бусад материалыг боловсруулж, Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж батлууллаа.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд богино хугацааны сургалтаар бэлтгэх боломжтой мэдээллийн технологийн 15 чиглэлийн 23 мэргэжлийн жагсаалтыг гаргаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлээ. БШУЯ-тай хамтран Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 115 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Дээд боловсролын тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн жагсаалтад мэдээллийн технологийн 11, 2 дугаар хавсралтаар батлагдсан дээд боловсролын эрэлттэй мэргэжлийн чиглэлийн жагсаалтад 3 мэргэжил тус тус орж батлагдсан.

3. Олон улсад ашигладаг цахим төлбөрийн системийг Монгол Улсад ашиглах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд Монголбанк PayPal, Stripe зэрэг олон улсын төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн Ази Номхон далайн бүс хариуцсан салбартай холбоо тогтоож, хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлсэн боловч Ази Номхон далайн бүсийн орнуудад дээрх төлбөрийн хэрэгслүүдийг нэвтрүүлэх ойрын 5 жилийн төлөвлөгөөнд Монгол Улс багтаагүй ба Монгол Улсын зах зээл харьцангуй бага, систем хөгжүүлэлт хийхэд цаг хугацаа, хөрөнгө их шаардлагатай гэсэн хариуг ирүүлсэн. Иймд дотоодын зах зээлд цахим худалдааны нөхцөл байдал холбогдох хууль эрх зүйн онцлогт нийцсэн PayPal, Stripe байгууллагатай ижил төстэй олон улсын цахим худалдааны

гүйлгээ төлбөр хүлээн авах өөр гарцыг судалж байна. Монголбанк болон Бүгд Найрамдах Солонгос Улсын КТ корпорацийн BC Card байгууллагатай хамтран ажиллах зорилгоор харилцан ойлголцлын санамж бичгийг 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан ба систем хоорондын холболтыг 2023 онд багтаан шийдвэрлэхээр ажиллаж байна.

Ингэснээр Үндэсний брэнд төгрөгийн картыг БНСУ-д, ВС картыг Монгол Улсад харилцан төлбөр хүлээн авах боломжийг бүрдүүлнэ. Дэлхийн 64 улсад нэвтэрсэн БНХАУ-ын тэргүүлэх цахим төлбөрийн хэрэгсэл Wechat pay төлбөр хүлээн авах системд Худалдаа хөгжлийн банк, Хаан банк, Тээвэр хөгжлийн банк, Hirau аппликэйшн харилцан холбогдолтоо хийж, харилцагчдадаа олон улсын цахим төлбөрийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

4. Нийтийн мэдээллийн систем үүсгэх, хөгжүүлэхтэй холбоотой төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаагаа эрхэлж байгаа үндэсний аж ахуйн нэгжийг дэмжих бараа, ажил, үйлчилгээний ашиглалт, хөгжүүлэлтийг нийлүүлэгч аж ахуйн нэгж тодорхой хугацаанд хариуцах эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд төрийн байгууллага мэдээллийн технологийн худалдан авалт хийхдээ нэн тэргүүнд дотоодын компаниудын бүтээгдсэн, бүтээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч байх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх. Үндэсний дэд бүтцэд суурилсан худалдан авалтын системийг бий болгох, түүнд байрших программ хангамжийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлагын талаар саналыг боловсруулж, Программ хангамжийн их дэлгүүр Mindgolia.mn цахим хуудсыг хөгжүүлж, ашиглалтад оруулснаар тус цахим системд 2023 оны 6 дугаар сарын байдлаар 29 ангилалд 378 хуулийн этгээдийн 385 бүтээгдэхүүн байршиж байна.

Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран Mindgolia.mn-нд байршсан бараа, бүтээгдэхүүнээс тодорхой шалгуурын дагуу сонгосон байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг Сангийн сайдын 2017 оны 236 дугаар тушаалаар батлагдсан ерөнхий гэрээний журамд зааснаар tender.gov.mn-д нийлүүлж, төрийн байгууллага шууд худалдан авах боломжийг судалж эхний ээлжид ERP системүүдийг цахим дэлгүүрт оруулж ажиллаж байна.

Улсын Их Хурлын эцсийн хэлэлцүүлгийн шатад байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 48.2.12 дахь заалтад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасан зөвлөмж, дүгнэлтэд үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах гэж тусгасан ба үүний үр дүнд төрийн байгууллага мэдээлэл, технологийн давхардсан, үр ашиггүй худалдан авалт хийх, хийхгүй байх нөхцөл бүрдэх болно.

Түүнчлэн Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалын хавсралт худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журмын 8.4-д захиалагч мэдээллийн систем үүсгэх, хөгжүүлэхтэй холбоотой бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасан зөвлөмж, дүгнэлт авсны үндсэн дээр зохион байгуулна гэж өөрчлөлт орууллаа.

5.Нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөрийн цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим төлбөрийн системтэй холбох ажлын хүрээнд нийт 20 байгууллагыг Ebarimt системтэй одоогийн байдлаар холбосон ба 2023 оны 5 дугаар сарын байдлаар

37927857 баримтыг утасны дугаараар бүртгэсэн. Мөн энэ оны 2 дугаар улиралд багтаан CU үйлчилгээний төвийг тус системтэй холбохоор 106 байгууллагын 61128 хэрэглэгчийн кассын системийг шинэчилж, 3.0 хувилбарыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

6.Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг сайжруулан олон улсын итгэмжлэгдсэн жагсаалтад оруулах ажлын хүрээнд одоо ашиглаж байгаа тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтэц нэмэлт хөгжүүлэлт хийх боломжгүй, цагийн бүртгэл хийгддэггүй зэрэг шалтгаанаас олон улсын итгэмжлэгдсэн жагсаалтад орох боломжгүй байна. Монгол Улсын суурь гэрчилгээжүүлэх байгууллагын өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан нийтийн түлхүүрийн дэд бүтцийн үндэсний суурь гэрчилгээжүүлэх байгууллагын техник тоног төхөөрөмж программ хангамжийг шинэчлэхэд шаардлагатай техник хөрөнгө оруулалтын судалгааг боловсруулж, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацитай байгуулсан Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэхээр саналыг тусгалаа. Уг төслийг хэрэгжүүлж, дэд бүтцийг олон улсын стандарт шаардлагад нийцүүлж шинэчилсний үндсэн дээр итгэмжлэгчийн жагсаалтад оруулах нөхцөл бүрдэнэ.

7.Ерөнхий боловсролын сургалтад тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх талаар агуулгыг тусгах, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон их, дээд сургуулиудад мэдээлэл технологи, программ хангамж, мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн сүлжээ, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжлэх ухаан зэрэг мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг өргөжүүлэх ажлын хүрээнд бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, Цахим хөгжил, харилцаа

холбооны сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Соёлын сайдын хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуульд ахлах ангийн сонгон судлах хичээлийг хэрэгцээ сонирхолд нь үндэслэн танхимаар судлах боломж бүрдээгүй сурагчдад цахимаар зохион байгуулах боломжийг бүрдүүлж, 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Монголын анхны цахим сургууль Medle.mn орон даяар нээлтээ хийж ажиллаж байна. 2022 оны 12 дугаар сарын байдлаар 10407 сурагч хамрагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт, 70 дугаар тогтоолд утасгүй холбоо, өгөгдлийн ухаан, системийн аюулгүй байдал, хиймэл оюун ухаан зэрэг мэргэжлийг нэмж тусгаж батлууллаа. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А160 дугаар тушаалаар Мэдээлэл харилцаа холбооны технологийн хиймэл оюун ухаан, өгөгдлийн ухаан, мэдээллийн аюулгүй байдал, ИОТ зэрэг 13 шинэ индексийг гаргасан.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын санхүүжилтээр хэрэгжиж байгаа мэдээллийн технологи аутсорсингийн төсөлд мэдээлэл, харилцаа холбооны технологийн инженер, оюутан залуус, багш нарын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт 401 багш сурагчид хамрагдсан. Үүнд Linux Training, Data Visual, AI and ML. Data Analytics, VMware, IOS, Java, Soft skills, Soft test, BPO, Cyber Security зэрэг багтсан.

8.Радио, өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг тоон технологид шилжүүлэхэд шаардлагатай судалгааг хийх, ач холбогдлыг тайлбарлан таниулах, санхүүжүүлэлтийг шийдвэрлэх ажлын хүрээнд Хонхорын аналогий радио өргөн нэвтрүүлгийн

дамжуулах станцыг тоон технологид шилжүүлэх ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж, тус төслийг БНСУ-ын Шинжлэх ухаан, харилцаа холбоо, мэдээлэл технологийн сайдтай 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хийсэн уулзалтаар танилцуулж, хамтарч ажиллаж байна. Монгол Улсын хэмжээнд Радио, телевизийн үндэсний сүлжээ улсын төсөвт үйлдвэрийн газрын хариуцдаг 6 сайт байдаг ба эдгээр сайтаас тоон технологид шилжих боломжтой Хөвсгөл, Говь-Алтай, Баян-Өлгий, Дорнод аймагт байрлах 4 сайтад их хүчний радио өргөн нэвтрүүлгийн хамрах хүрээ болон дохионы чанарын үнэлгээг 3 дугаар улиралд багтаан хийхээр ажиллаж байна. 2023 оны 3 дугаар сард Хөвсгөл аймгийн сайтад хийсэн болно.

9.Нийгмийн мэдээллийн сүлжээ, цахим хуудас, өргөн нэвтрүүлгийн радио, телевизээр дамжуулан бүх нийтийн тоон бичгийн үсгийн чадавхыг дээшлүүлэх, соёлтой хэрэглээг төлөвшүүлэх талаар ойлголт, мэдлэг, мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд. И-Монгол УТҮГ-ын Цахим ур чадварын газар 2023 онд бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх 64 удаагийн сургалтаар нийт 2084 иргэн, 40 удаагийн сургалтаар 1769 төрийн албан хаагчдыг хамрууллаа.

Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах талаар мэдлэг, мэдээлэл олгох, цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, олон нийтийн дунд үе тэнгийн дарамт, ялгаварлан гадуурхалтын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, энэ төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 4 дүгээр сард “Найз байя” үндэсний аяныг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Дэлхийн Зөн Монгол Улс, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран зохион байгууллаа. Өсвөр үеийнхэнд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах талаарх мэдлэг мэдээллийг

олгох, цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, нийгмийн сүлжээний олон талт асуудлуудыг судалж, өөрийн болон бусдын үзэл бодлыг хүндэтгэх, үзэл бодлоо чөлөөтэй, нээлттэй илэрхийлэх, багаар хамтран ажиллах чадварыг хөгжүүлэх зорилготой Цахим орчин хүүхдийн эрх сэдэвт мэтгэлцээний улсын аварга шалгаруулах тэмцээнийг Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын Карл Попперын мэтгэлцээний нийгэмлэгтэй зохион байгууллаа.

Өргөн нэвтрүүлгийн контенцыг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, МҮОНРТ хамтран Цахим орчин хүүхдийн эрх сэдэвт мэтгэлцээний улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Мэдээллийн технологийн салбарын охидын өдрийг *Digital skills for life* уриалган доор Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, *Women Techmakers Mongolia* коммунититай хамтран мэдээллийн технологийн салбарт охидын оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэших, дэмжих зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн охидод мэдээллийн технологийн салбарын мэргэжил, онцлог, давуу талын талаар ойлголтуудыг өгч мэдээлэл өгөх, цахим орчинд эрхээ хэрхэн хамгаалах талаар зөвлөх уулзалтыг зохион байгуулсан.

10.Цахим баримт бичиг нь цаасан баримт бичгийн адил хүчинтэй байх хууль, эрх зүйн зохицуулалтыг хангаж, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, иргэн, хуулийн этгээдийн төрийн байгууллагаас авах үйлчилгээг цахимжуулах, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрч нотлох баримтын хэмжээнд үнэлэх нөхцөлийг бүрдүүлэхээр хууль хоорондын давхардал, хийдэл,

зөрчлийг арилгах зорилго бүхий нийт 120 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ажиллаж байна.

11.Эрүүл мэндийн, боловсролын болон нийгмийн хамгааллын салбарын цахимжилтын хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт төрийн аудитын байгууллагаар мэдээлэл технологийн аудит хийлгэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас Цахим Монгол зорилтын хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний явц, үр дүн сэдэвт аудитыг Аудитын ерөнхий газартай хамтран 2023 оны 3-аас 4 дүгээр улиралд хийхээр төлөвлөж, бэлтгэл ажил эхэлсэн ба одоогоор аудитын урьдчилсан судалгааны ажлын уулзалтыг зохион байгуулж эхлээд байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Э.Батшугар: Баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Н.Учрал Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Б.Билэгдэмбэрэл Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, П.Дэлгэрмаа Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Б.Мягмарнаран И-Монголиа Академи УТҮГ-ын захирал, М.Баттулга Үндэсний дата төв УТҮГ-ын дарга, Т.Батбилэг Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ын захирал, Насанбат Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Инновац, цахим бодлогын байнгын хорооноос 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан Засгийн газарт чиглэл өгөх тухай 01 дүгээр тогтоолын

хэрэгжилтийн талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Ундрам гишүүнээр тасалъя. Ундрам гишүүн.

Ч.Ундрам: Энэ цахим Инновац, цахим бодлогын байнгын хороо байгуулагдаад Цахим хөгжлийн яам байгуулагдаад ер нь бол төрийн нэлээн олон үйлчилгээ иргэдэд илүү ойр, хүнд сурталгүй болж, дэвшил нэлээн гарч байгаа. Энэ боловсролын салбарын хувьд миний бас нэг санаа зовж байгаа зүйл болохоор энэ чиглэлийн боловсон хүчин бэлтгэх асуудал бол нэлээд хүндэрчихсэн байгаа. МУИС, ШУТИС дээр тодорхой хэдэн оюутнууд бол бэлтгэгдэж байгаа байх. Тэгээд энэ сургуулиуд дээр, би МУИС-ийн дэд захирлаар ажиллаж байсан хүний хувьд энэ салбарынхан чинь дэлхий даяар маш өндөр цалин авдаг. Их сургуульд багшлах хүн бараг олдохгүй. Зүгээр нөгөө багш нар маань зүрх сэтгэлээрээ мөнгө дагаад явах юм бол ингээд гадаад руу бараг гараад явчихаар, тэгээд нөгөө зүрх сэтгэлийн дуудлагаараа гэдэг шиг МУИС, ШУТИС дээр энэ хэдэн сургуулиуд дээр бол багшлаад байж байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт ийшээгээ нөгөө сурахаар орсон оюутнууд маань төгсөхөөсөө өмнө гадаадын компаниуд ирээд нөгөө гадаад хэлээ заагаад бараг ажилд аваад явчихдаг. Тэгэхээр Монголдоо энэ чиглэлийн мэргэжилтнүүдийг авч үлдэх бодлого гэж байна уу? Энэ төрийн албан хаагчийн цалин бол манайх ер нь нийтээрээ маш бага байгаа шүү дээ. Гэтэл энэ IT-гийн салбар дэлхийд маш хурдтай хөгжиж байна, дэлхийд цалин нь бүүр ингээд топ болчихсон байж байдаг. Тэгэхээр бид нар энэ чиглэлийн боловсон хүчнээ яаж бэлдэх юм бэ, яаж авч үлдэх юм бэ, энэ хүний нөөцийн асуудал дээр ямар бодлого боловсруулах шаардлагатай байгаа юм бэ гэсэн асуулт байна.

Э.Батшугар: Учрал сайдын микрофоныг нээе.

Н.Учрал: Ундрам гишүүн их чухал асуудлыг хөндлөө. Тэгээд манай салбарт бол хүний нөөцийн хомсдол бий болсон. Төрийн албан хаагчдын цалинтай дүйцүүлээд яг мэдээллийн технологийн нарийн мэргэжилтнүүдийг яг төрийн захиргааны албан тушаал дээр буюу төрийн жинхэнэ албан хаагчаар ажилд авахад бол маш их бэрхшээлтэй байгаа. Ингээд төр өөрөө цалингаа нэмээд эсвэл мэдээллийн технологийн чиглэлийн нарийн мэргэжилтнүүдийнхээ цалинг нэмэгдүүлээд яваад байх нь өөрөө хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд байх нэг ийм суурь хөрсийг бий болгочих учраас манай салбарын онцлог бол өөрөө хувийн хэвшил төрийн ямар нэгэн дэмжлэггүйгээр урагшилж байгаа салбар учраас хувьд байгаа сайн мэргэжилтнүүдийг төр лүү татаж авах тийм бодлогыг бол барьж ажиллах нь буруу гэж үздэг. Тэр ч утгаараа бид бол манай салбарт программ хангамжийн худалдан авалтыг зохион байгуулахдаа тэр Mindgolia дээр байгаа бүтээгдэхүүнээсээ худалдаж ав, давхардсан тендер худалдан авалт зарлахаа болио гэдэг утгаараа энэ Mindgolia дээр хувийн хэвшлийн бүтээсэн программ хангамжуудыг байршуулаад, төр түүнээсээ худалдаж авдаг ийм зөв жишиг рүү манай салбар бол явж байгаа.

Одоо ингээд Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль дээр Цахим хөгжлийн яам программ хангамжуудад үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгөөд явдаг. Дээрээс нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулиар Цахим яаманд мэдээллийн технологийн аудит хийх, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх байгууллагуудад эрхийг олгох эрх байдаг сайдад. Тэгэхээр энэ эрхийг хэрэгжүүлэхийн тулд бол бид нар мэдээж төр өөрөө чадварлаг байж тухайн аудит хийх байгууллагуудад нь эрх олгоно. Энэ ч утгаараа бол төр систем хөгжүүлэхээс бол татгалзъя л

гэж байгаа юм. Систем хөгжүүлэхээс татгалзъя. Тэгэхдээ бодлого боловсруулах түвшиндээ мэргэжлийн түвшинд нэг хэлээр ярьдаг байх ёстой гэдэг утгаараа бол тэр мэдээллийн технологийн нарийн мэргэжлээр өндөр ур чадвартай хүнийг ажиллуулахдаа цалингийн итгэлцүүр шатлалыг Засгийн газар тогтооно гэж Цахим гарын үсгийн хуулийг баталж байхад Төрийн албаны хуульд өөрчлөлт оруулсны дагуу бид нар Засгийн газраар энэ цалингийн итгэлцүүрийг шинээр батлуулсан.

Энэ цалингийн итгэлцүүр батлуулснаараа нэг яаман дээр 1-3 хүн, нэг агентлаг дээр 1-3 хүн гүйцэтгэх, туслах гэсэн албан тушаалын ангилал дээр төрийн үйлчилгээний албан тушаал дээр цалин нь бол өндөр байгаа. Ийм боломжийг бүрдүүлсэн. Сайд бол баталсан төсвийнхөө багцын хүрээнд энийг шийдвэрлэж байгаа. Тэгэхээр систем хөгжүүлэх гэхээсээ илүүтэйгээр нөгөө систем хөгжүүлж байгаа хувийн компаниуддаа ядаж тендерээ зарлахдаа ухаалаг тендер зарламаар байгаа юм. Мэргэжлийн тендер зарламаар байгаа юм. Мэргэжлийн худалдан авалт зарлаад, нөгөө компани ажлаа гүйцэтгээд ирэхэд нь, тухайн ажлыг нь хүлээж авахдаа мэргэжлийн байдлаар харьцахгүй бол олон төсөл, хөтөлбөр мэргэжлийн байдлаар харьцаж чадаагүйгээсээ болоод цахим эрүүл мэнд төслөөс авхуулаад уналтад орсон гэдгийг бид мэдэж байгаа учраас төр бол цаашидаа ухаалаг худалдан авагч байна, мэргэжлийн байна. Тэгэхээр 1 яаманд 1-2, зарим яаманд 3 хүн ажиллаад, тэр тэдгээр хүмүүс бол тэр ТҮ дээрээ цалин аваад, энэ нарийн мэргэжлүүдээр. Жишээ нь энэ нарийн мэргэжил дотор бол сая индекс дээр шинээр бид нар хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжээч, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлийн мэргэжилтнүүдийг бүүр ингээд нарийн зааглаад индексийг шинээр оруулсан. Тэгээд энэ утгаараа бол манай сургуулиуд хийх байх.

Дээрээс нь бид нар бол ШУТИС-тай хамтраад бас энэ хөтөлбөр боловсруулах ажил дээр оролцож байна. Батлан хамгаалах их сургуультай хамтраад кибер аюулгүй байдал дээр хөтөлбөр боловсруулах гээд ажиллаж байна гээд бас салбарын хувьд бол тодорхой мэргэжлийн хүний нөөцийн эрэлтээ бол энэ дээд боловсролын байгуулагатайгаа зарлаж, хамтарч ажиллаж байгаа.

Э.Батиугар: 2, ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе.

Б.Мягмарнаран: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. И-Монгол Академийн захирал Мягмарнаран. Яг саяын асуудал бол яг тулгамдаад байгаа асуудал. Тэгээд И-Монгол Академийн зүгээс бол бид нарын бас нэг үндсэн чиг үүргийн нэг нь бүх нийтийн цахим боловсролыг дээшлүүлэх чиглэлээр ажилладаг. Үүний хүрээнд болохоор бид нар олон нийтэд чиглэсэн төрийн албан хаагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гээд зорилтот бүлэгт чиглэсэн сургалтуудыг зохион байгуулдаг байгаа.

Бидний хувьд бас их, дээд сургуулиудтай хамтарч ажиллахаар уулзалтуудыг хийгээд явж байгаа. Яг бид нарын хувьд бол мэргэжлийн боловсон хүчний хувьд бол тулгамдаад байгаа асуудал байгаа. Манай ажилтны дундаж нас бол 24 орчим настай. Энэ нь хэдийгээр залуу гэж байгаа боловч нөгөө талаар бас нөгөө сул тал нь туршлага багатай байна гэж харагдаж байгаа. Тэгээд энэ үүднээсээ бид нар бас их, дээд сургуулиудтай, МУИС-тай уулзалтыг хийсэн. Тэгээд үүнтэй чиглэсэн боловсон хүчин бэлдэх чиглэлээр хамтарч хөтөлбөрт нь санал өгөхөөр ажиллаж байна. Баярлалаа.

Э.Батиугар: Баярлалаа. Байнгын хорооноос 2022 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг,

мэдээлэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Инновац, цахим бодлогын байнгын хорооноос 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан Засгийн газарт чиглэл өгөх тухай 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсож дууслаа.

14.41 цаг

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсэгт мөн баярлалаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА*